

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2024 оны 07 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ-ий өсөлт

(2024 оны эхний хагас жил)

5.6 хувь

Валютын нөөц

(2024 оны 7 дугаар сар)

4,737 сая \$

Инфляц

(2024 оны 7 дугаар сар)

5.5 хувь

Төсвийн тэнцэл

(2024 оны 7 дугаар сар)

1.6 их наяд ₮

Экспорт

(2024 оны 7 дугаар сар)

9,266 сая \$

Импорт

(2024 оны 7 дугаар сар)

6,411 сая \$

ГШХО

(2024 оны 1 дүгээр улирал)

885 сая \$

Зээлийн хүү

(2024 оны 6 дугаар сар)

17.1 хувь

Ажилчдын тоо

(2024 оны 2 дугаар улирал)

1.3 сая

*1| Улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 62 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2024 оны 1 дүгээр улирал)

15.4 хувь

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2024 оны 2 дугаар улирал)

99.1 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2024 оны 2 дугаар улирал)


17.3 хувь



2024 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт 5.6 хувь байна. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарын үйлдвэрлэл эерэг нөлөө үзүүлсэн хэвээр байна. Өмнөх оны өндөр суурийн нөлөөгөөр уул уурхайн салбарын оролцоо багасаж, үйлчилгээний салбар эдийн засгийн өсөлтийг тэтгэж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(2024 оны 1 дүгээр улирал)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛ УУРХАЙ


(бодит үйлдвэрлэлийн хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨДӨӨ АЖ АХУЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2024 оны эхний хагас жилд **5.6 хувиар өслөө.**
- Анхдагч салбар: Уул уурхайн салбар 15.4 хувиар тэлж өсөлтийн 1.8 хувийг, ХАА-н салбар 26.7 хувиар агшиж өсөлтийг -3.9 нэгж хувиар хязгаарлалаа.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 7.9 хувиар өсөж өсөлтийн 0.8 нэгж хувийг;
- Үйлчилгээний салбар /худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 9.3 хувиар өсөж өсөлтийн 4.4 хувийг ;
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 15.0 хувиар өсөж өсөлтийн 2.3 хувийг бүрдүүлсэн байна.

- Үйлчилгээний салбар болон цэвэр татварын орлого нэмэгдсэнээр өсөлтийн дийлэнхийг бүрдүүлж байна. Мөн боловсруулах, барилгын салбарын үйлдвэрлэл өсөлттэй байв.
- Харин том малын зүй бус хорогдол нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбар агшив.

- Уул уурхайн салбар 2024 оны эхний хагас жилд 15.4 хувиар тэллээ.
- Газрын тос, молибдений баяжмал, алтны олборлолтоос бусад уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн олборлолт нэмэгдсэнээр уул уурхайн салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөллөө.

- ХАА-н салбар 2024 оны эхний хагас жилд 26.7 хувиар агшлаа.
- Том малын зүй бус хорогдол 2024 оны 2 дүгээр улирлын байдлаар 8.1 сая толгойд хүрч өмнөх оны мөн үеэс 4.2 сая толгой малаар нэмэгдлээ. Энэ нь оны эхний нийт малын 12.5 хувийг эзэлснээр хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл жил дараалан буурч байна.



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 7 сард 16 хувиар өсөв. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн олборлолт уул уурхайн салбарын үйлдвэрлэлд эергээр нөлөөлж байгаа бол хөнгөн болон хүнд үйлдвэрлэл боловсруулах салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж байна.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(тэрбум төгрөг)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2024 оны эхний 7 сард 18.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16 хувиар өслөө.
- Нүүрс, төмрийн хүдэр, зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 20 хувиар нэмэгдээд байна.
- Хөнгөн болон хүнд үйлдвэрлэл нэмэгдэж, боловсруулах салбарын үйлдвэрлэл 4.3 хувиар өслөө.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(ҮҮИ-ээр засварласан бодит дүн, тэрбум төгрөг)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, УСХ

- Тус салбарын бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) 2024 оны эхний 7 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.0 хувиар өсөөд байна. Үүнд:
 - Салбарын дийлэнхийг эзэлдэг уул уурхайн салбарын үйлдвэрлэл 12.9 хувиар өсөж, гол нөлөө үзүүлэв.
 - Харин зудын улмаас малын хорогдол нэмэгдэж, мах боловсруулах үйлдвэрлэл буурснаар нийт боловсруулах үйлдвэрлэл бодит дүнгээр буурсан үзүүлэлттэй байна.

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ


(голлох бүтээгдэхүүнээр)

	өмнөх оноос өөрчлөлт:
Нүүрс	54 сая тонн 34%
Зэсийн баяжмал	846 мян.тонн 2.5%
Газрын тос	2.5 сая баррель -14%
Алт	6.8 тонн -13%
Төмрийн хүдэр	5,453 мянган тонн 44%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Нүүрс олборлолт 2024 оны эхний 7 сард 54 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 34 хувиар нэмэгдээд байна.
- Төмрийн хүдэр, баяжмал олборлолт өмнөх оны мөн үеэс сэргэж 44 хувиар өсөв.
- Зэсийн баяжмал үйлдвэрлэл 2.5 хувиар өсөж 846 мянган тоннд хүрсэн байна.
- Харин алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс буурсан хэвээр байна.

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 9.3 хувиар, цар тахлын өмнөх үеэс 78.0 хувиар өслөө. Үнийн индексийг бүрэлдэхүүнээр харвал:

Үнэ өссөн:


- Хүнсний бүтээгдэхүүн 9.8 хувиар,
- Ундаа, согтууруулах ундаа 9.4 хувиар,
- Нэхмэлийн үйлдвэрлэлийнх 9.8 хувиар тус тус өссөн бол

Үнэ буурсан:

- Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийнх 1.2 хувиар
- Цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийнх 1.4 хувиар тус тус буурсан.



Дотоод эрэлт идэвхжил сайн, эдийн засгийн өсөлтийг тэтгэж байна.



- Эрэлтээс тооцсон ДНБ 2024 оны эхний хагаст 5.7 хувиар өслөө.
- Өсөлтөд эцсийн хэрэглээ 21.5 нэгж хувийн, хөрөнгийн хуримтлал 6.2 нэгж хувийн тус тус зэрэг нөлөө, цэвэр экспорт 21.9 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлэв.

- Тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалинг нэмсэнтэй холбоотойгоор төрийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 46.9 хувиар өсөж, нийт эрэлтийг дэмжиж байна.
- Өрхийн бодит орлого 17.3 хувиар сайжирснаар нийт өрхийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар нэмэгдэв.


- Үндсэн хөрөнгийн хуримтлал өмнөх оны түвшинд байна.
- Машин тоног төхөөрөмж 16.8 нэгж хувиар, орон сууцны бус барилга байгууламж 6.9 нэгж хувиар, оюуны өмч 2.5 нэгж хувиар үндсэн хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүлсэн бол биологийн өсөж үрждэг хөрөнгө 25.6 нэгж хувиар бууруулсан байна.

- Үйлчилгээний экспортын орлого өмнөх оны мөн үеэс багасаж, нүүрс, зэсийн баяжмалын үнийн бууралтаас шалтгаалан бараа, үйлчилгээний экспорт 2024 оны хагасад өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар буурав.
- Бараа, үйлчилгээний импорт өмнөх оны мөн үеэс 20.6 хувиар өсөв. Үүнд барааны импорт 29.4 хувиар, үйлчилгээний импорт 10.4 хувиар өссөн байна.



2024 оны эхний 7 сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 15.7 тэрбум ам.доллар, тэнцэл 2.8 тэрбум ам долларын ашигтай гарлаа.


ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 2024 оны эхний 7 сард 9,266 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 6 хувиар өслөө.
- Нийт экспортын 93 хувийг уул уурхай бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 59 хувийг бүрдүүлж байна.


ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспортын орлого 5,361 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өслөө.
- Зэсийн баямжлын экспортын орлого 1,747 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 474 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 348 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар өслөө.

ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2024 оны эхний 7 сард импорт 6,411 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 27.6 хувиар өссөн байна.
- Нийт импортын 18.7 хувийг тоног төхөөрөмж, 17.6 хувийг нефть, 8.8 хувийг автомашин эзэлж байна.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар


- Тоног төхөөрөмжийн импорт 1,202 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 42.0 хувиар өслөө.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 1,131 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 21.7 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 566 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 47.1 хувиар өслөө.



2024 оны эхний 7 сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 93 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 80 хувийг бүрдүүллээ.

НҮҮРС


(сая тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЗЭСИЙН БАЯМЖАЛ


(тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТӨМРИЙН ХҮДЭР


(мян. тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГАЗРЫН ТОС

(мян. баррель)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспорт 2024 эхний 7 сард 46.1 сая тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 26.3 хувиар өслөө.
- Гашуунсхайт боомтоор 20.3 сая тонн, Шивээхүрэн боомтоор 11.8 сая тонн, Ханги боомтоор 1.8 сая тонн, бусад боомтуудаар 5.5 сая тонн нүүрс тус тус экспортолсон байна.

- Зэсийн баяжмалын экспорт 2024 эхний 7 сард 928 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3.9 хувиар өслөө.
- Гашуунсхайт (Оюу-Толгой) боомтоор 487 мянган тонн, Замын-Үүд (Эрдэнэт) боомтоор 298 мянган тонн зэсийн баяжмал тус тус экспортолсон байна.


- Төмрийн хүдрийн экспорт 2024 эхний 7 сард 4,250 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 26.6 хувиар өслөө.
- Замын-Үүд боомтоор 3,233 мянган тонн, Бургастай боомтоор 322 мянган тонн, бусад боомтуудаар 41 мянган тонн төмрийн хүдэр тус тус экспортолсон байна.

- Газрын тосны экспорт 2024 оны эхний 7 сард 2,065 мянган баррельд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 15.6 хувиар буурлаа.
- Баянхошуу боомтоор 1,894 мянган баррель, Замын-Үүд боомтоор 171 мянган баррель газрын тос тус тус экспортолсон байна.




2024 оны эхний 7 сарын байдлаар сарын голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.

МАЛЫН МАХ (тонн)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

АРЬС ШИР (мянган дм квадрат)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООЛУУР (тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООС (тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Малын махны экспорт 2024 оны эхний 7 сард 22,205 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 43 хувиар буурлаа.
- Тэр дундаа боловсруулсан махны экспорт өмнөх оны мөн үеэс 3 дахин багасаж 6,615 мянган тоннд хүрлээ.

- Боловсруулсан арьс ширний экспорт 2024 оны эхний 7 сард 52,538 мянган дм квадратад хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 31 хувиар буурлаа.

- Ноолуурын экспорт 2024 оны эхний 7 сард 4,022 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 9 хувиар өслөө.


- Ноосны экспорт 2024 оны эхний 7 сард 111 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 45 хувиар буурлаа.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

ЗЭС


(\$/тонн, Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

ТӨМРИЙН БАЯЖМАЛ

(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламттай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Brent)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2024 оны эхний 7 сарын дундаж үнэ 244 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3 хувиар буурсан байна.

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2024 оны эхний 7 сарын дундаж 9,394 ам.доллар болж, өмнөх оны мөн 11 хувиар өссөн байна.

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2024 оны эхний 7 сарын дундаж үнэ 107 ам.доллар болж, өмнөх оны мөн үетэй адил түвшинд байна.


- Бrent газрын тосны 2024 оны эхний 7 сарын дундаж үнэ 83 ам.долларт хүрч өмнөх оны эцсээс 2 хувиар өслөө.



2024 оны эхний 7 сарын байдлаар УУББ-ээр нийт 31 сая тонн нүүрс болон 1.8 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 5.4 мянган тонн зэсийн баяжмал, 6.5 мянган тонн жоншны баяжмалыг арилжаалаад байна.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА

(сая тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2024 оны 7 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 31 сая тонн нүүрс арилжиж, 4.1 тэрбум ам.долларын орлого олжээ
- 2024 оны 7 дугаар сарын байдлаар 2024 онд 16.4 сая тонн нүүрс арилжиж, 1.9 тэрбум ам.долларын орлого олжээ.
- 2024 оны 7 дугаар сард 1.6 сая тонн нүүрс борлууллаа.

НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 7 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 113 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 118 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 7 дугаар сард хэлцлийн доод үнэ 52 ам.доллар, дээд үнэ 159 ам.долларт хүрэв.

ТӨМРИЙН АРИЛЖАА

(мянган тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2024 оны 7 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 1.8 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 141 сая ам.долларын орлого олжээ
- 2024 оны 7 дугаар сарын байдлаар 2024 онд 1,168 мянган тонн төмрийг арилжаалж, 84 сая ам.долларын орлого олжээ.

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- Төмрийн хүдэр болон баяжмалын 7 дугаар сарын дуудах дундаж үнэ 70 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 72 ам.доллар болж өсөв.
- Төмрийн төрлөөс хамааран 7 дугаар сард хэлцлийн доод үнэ 70 ам.доллар, дээд үнэ 75 ам.долларт хүрэв.




Монголбанк 2024 онд своп хэлцлийн 4.5 тэрбум юань буюу 620 орчим сая ам.долларын төлбөрийг хийлээ. Улмаар төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 6 сарын байдлаар 57 сая ам.долларын алдагдалтай гарч, гадаад валютын улсын нөөц 2024 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар 4.7 тэрбум ам.долларт хүрлээ.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ (сая ам.доллар)




Тэмдэглэл: Төлбөрийн тэнцлийн статистикийг 1 сарын хэцрөгдөлтой зарлагддаг.
Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

ХАНШИЙН ӨДРИЙН ӨӨРЧЛӨЛТ (төгрөг/ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

- Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 6 сард 57 сая ам.долларын алдагдалтай гарч, тэнцэл өмнөх оны мөн үеэс 531 сая ам.доллараар муудлаа.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 0.7 тэрбум ам.доллараар нэмэгдсэн ч импортын өсөлт 1.2 тэрбум ам.долларт хүрснээр урсгал данс алдагдалтай гарлаа.
- Төлбөрийн тэнцлийн шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал* 2024 оны эхний 6 сард 1.3 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 437 сая ам.доллараар өссөн байна.

- Гадаад валютын улсын нөөц 2024 оны 7 дугаар сарын эцэст 4,737 сая ам.доллар болж, өмнөх сараас 102 сая ам.доллараар буурч, өмнөх оны мөн үеэс 0.9 тэрбум ам.доллараар буюу 23.8 хувиар өслөө.

- Төгрөгийн ам.долларт харьцах ханш 2024 оны 7 дугаар сард өдөрт дунджаар 0.01 төгрөгөөр чангарч, сарын эцэст 3,381 болж, оны эхнээс 30 төгрөгөөр буюу 0.9 хувиар чангарлаа.


- Төв банк 2024 оны эхний 7 сард нийт 3,595 сая ам.долларыг зах зээлд нийлүүлжээ.
- Энэ нь 2023 оны мөн үеэс 76.7 хувиар буюу 1,562 сая ам.доллараар өндөр дүн боллоо.

*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн




Инфляц 2024 оны 7 дугаар сард 5.5 хувьд хүрлээ. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.1 хувиар өссөн байна.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ (хувь)




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

САРЫН ИНФЛЯЦ (хувь)




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

СУУРЬ ИНФЛЯЦ (хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ (хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Инфляц 2024 оны 7 дугаар сард улсын хэмжээнд 5.5 хувьд гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 1.9 нэгж хувь (34.7%)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 3.6 нэгж хувь буюу 65.3 хувийг эзэлж байна.

- 2024 оны 7 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.1 хувиар өсөв.
- Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.1 хувиар өсөхөд хувцас, бөс бараа, гутлын бүлэг 48 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 34 хувь, бусад бараа, үйлчилгээ 65 хувиар тус тус өсөж, хүнсний үнэ 237 хувиар буурсан нь нөлөөлжээ.


- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2024 оны 7 дугаар сард суурь инфляц 5.4 хувь гарч, нийт инфляцын 3.6 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн сард өслөө.

- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2024 оны 7 дугаар сард жилийн инфляцын 10 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар өсжээ.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өсөв.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар өслөө.



Олон улсад чингэлэг тээврийн үнэ 5,551 ам.доллар болсон нь импортын инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна. Хүнсний үнийн индекс 2024 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар буурлаа.

ХҮНСНИЙ БА ХҮНСНИЙ БУС ИНФЛЯЦ




- Хүнсний инфляц 2024 оны 7 дугаар сард 5.6 хувь болж, нийт инфляцын 1.7 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хүнсний бус инфляц 5.1 хувь болж, нийт инфляцын 3.8 нэгж хувийг бүрдүүллээ.

ИМПОРТЫН ИНФЛЯЦ БА ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ




- Төгрөгийн амдоллартой харьцах ханш 2024 оны 7 дугаар сард дунджаар 3,380 төгрөг болж, өмнөх сараас өөрчлөгдөөгүй байна.
- Валютын ханш өөрчлөгдөөгүй хэдий ч импортын бараа бүтээгдэхүүний үнэ өмнөх сараас 0.4 хувиар өсжээ.

ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ҮНЭ



- Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис/Суэцийн сувагт үүсээд буй халдлагаас үүдэн 2024 оны 8 дугаар сарын 12-ны байдлаар 40 фут контейнер 5,551 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 210 хувиар өссөн байна.
- Энэ нь 2019 оны дундаж үе (цар тахлын өмнөх)-ээс 291 хувиар өндөр үзүүлэлт юм.
- Чингэлэг тээврийн үнэ өсөж байгаа нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна.

ХҮНСНИЙ ҮНИЙН ИНДЕКС



- НҮБ-ийн ХХААБ-аас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс нь хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- 2024 оны 7 дугаар сард хүнсний үнийн индекс 120.8 болж, өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар буурчээ.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээрх ургамлын тос, мах болон элсэн чихрийн үнэ өсөж, үр тарианы үнэ буурсан бөгөөд сүүн бүтээгдэхүүний үнэ бараг өөрчлөгдөөгүй байна.



Монгол Улсын нэгдсэн төсөв 2024 оны 7 дугаар сарын байдлаар 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн орлого нэмэгдэхэд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар өссөн нь голлон нөлөөллөө.


ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ

(их наяд төгрөг)




ТӨСВИЙН ОРЛОГО

(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



2024 ОНД НЭМЭГДСЭН ГОЛЛОХ ЗАРЛАГУУД

(зарлагын ангиллаар, их наяд төгрөг)



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(их наяд төгрөг, ДНБ-д эзлэх хувь)



- Нэгдсэн төсөв 2024 оны 7 дугаар сард 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 213 тэрбум төгрөг буюу 15.7 хувиар нэмэгдсэн байна.

- Орлого 2024 оны 7 дугаар сард 17.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.7 их наяд төгрөг буюу 37.5 хувиар нэмэгдсэн байна.
- Дээрх өсөлтөд орлогын албан татвар 2.2 их наяд төгрөг буюу 70.3 хувиар, НӨАТ 737.7 тэрбум төгрөг буюу 29.7 хувиар, нийгмийн даатгалын орлого 385.7 тэрбум төгрөг буюу 18.6 хувиар, АМНАТ 11.1 тэрбум төгрөг буюу 0.4 хувиар тус тус нэмэгдсэн нь голчлон нөлөөллөө.


- Зарлага 2024 оны 7 дугаар сард 15.3 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 4.2 их наяд төгрөг буюу 37.8 хувиар нэмэгдсэн байна.
- 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн бүх албан хаагчдын цалинг 10 хувиар, нийтлэг үйлчилгээний ажиллагсдын цалинг 20 хувиар, аллагдсан аймаг, сумд дүүргийн төрийн албан хаагчдын цалин 20-40 хувиар нэмэгдүүлээд байна.

- Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдэл 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 26.2 их наяд төгрөгт хүрч, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 33 хувьд хүрээд байна.
- Засгийн газрын өр (ӨҮЦ)-ийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.




Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 30.6 хувьд хүрч, өмнөх сараас 1.3 нэгж хувиар буурлаа. Төгрөгийн харилцах, хадгаламж, гадаад валютын харилцах өсөлттэй байсан бөгөөд гадаад валютын хадгаламж буурлаа. Зээлийн хүү 6 дугаар сард өмнөх сараас 0.2 нэгж хувиар нэмэгдэж, 17.1 хувьд хүрлээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж: Монгол банк

ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ (жилийн өсөлт, хувь)




Эх сурвалж: Монгол банк

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (хувь)



Эх сурвалж: Монгол банк

ХҮҮГИЙН ТҮВШИН (жигнэсэн дундаж хувь)



Эх сурвалж: Монгол банк

- Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 7 дугаар сарын эцэст 41.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 30.6 хувиар өссөн байна.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 17.5 нэгж хувийг, төгрөгийн харилцах 12.2 нэгж хувийг, гадаад валютын харилцах 1.6 нэгж хувийг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.4 нэгж хувийг гадаад валютын хадгаламж -1.2 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.

- Нийт хадгаламж 24.6 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 26.9 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 20.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 38.8 хувиар, өмнөх сараас 2.2 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгаламж 4.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар, өмнөх сараас 1.4 хувиар тус тус буурлаа.

- Банкнүүдэн зээлийн үлдэгдэл 2024 оны 5 дугаар сарын эцэст 31.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 28.2 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 6.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар буурсан байна.

- Банкнүүдэн зээлийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 5 дугаар сард 16.9 хувь болж, өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурч, өмнөх оны мөн үетэй ижил түвшинд хүрлээ.
- Банкнүүдэн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2024 оны 5 дугаар сард 11.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өслөө.

Тэмдэглэл: Зээл, хадгаламжийн хүүгийн үзүүлэлтийн 7 дугаар сарын статистик 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр зарлагдана.



Цар тахлын нөлөөгөөр буураад байсан хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр сэргэж цар тахлын өмнөх түвшинг давлаа.



- Ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 68 мянгаар нэмэгдэж 1,347.1 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 184.9 мянгаар өндөр үзүүлэлт юм.
- 2024 оны 2 дугаар улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 44.1 мянгаар нэмэгдсэн бол эмэгтэй ажилчид өмнөх оны мөн үеэс 23.9 мянгаар өссөн үзүүлэлттэй байна.

- Ажилчдын тооны өсөлтөд худалдаа, үйлчилгээ ба бусад, тээвэр, боловсруулах, уул уурхай, барилгын салбарын ажилчид нэмэгдсэн нь эергээр нөлөөлсөн байна.
- Харин өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсний улмаас хөдөө аж ахуйн салбарын ажилчид мөн ус, цахилгааны салбарын ажилчдын тоо буурсан нь сөргөөр нөлөөллөө.

- Ажиллах хүчний оролцооны түвшин 62.2 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар, цар тахлын өмнөх үеэс 1.2 нэгж хувиар өслөө.
- Харин ажилгүй иргэдийн тоо 2024 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 6.1 мянган хүнээр өсөж 82.3 мянгад хүрлээ.
- Ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өсөж 5.8 хувьд хүрлээ.

- Дундаж цалингийн хэмжээ 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 24.7 хувиар өсөж 2 сая 284 мянган төгрөгт хүрлээ.
- Улсын медиан цалин 2024 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 15.6 хувиар өсөж 1 сая 788 мянган төгрөг болов. Энэ нь дундаж цалингаас 485 мянган төгрөгөөр бага байна.
- Салбараар авч үзвэл уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж улсын дунджаас 2.5 дахин өндөр байна.



Инфляц, төгрөгийн ханш тогтвортой байдал болон цалингийн өсөлт өрхийн орлогод эерэг нөлөө үзүүлж байна. Орлогын өөрчлөлт хүн амын ялгаатай бүлгүүдийн хувьд харилцан адилгүй байна.


ӨРХИЙН БОДИТ ОРЛОГЫН ӨСӨЛТ (хувь)




ДУНДАЖ ОРЛОГЫН БҮТЭЦ (хувь)



ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО (сая төгрөг)



ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО (сая төгрөг)



- Өрхийн бодит орлого 19.8 хувиар сайжирлаа.
- Өрхийн орлого нэрлэсэн дүнгээр 2.4 сая төгрөг болж өсөхөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс 21.9 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

- Өрхийн орлогын 57 хувийг цалингийн орлого бүрдүүлж байна.
- Цалингийн орлого цар тахлын өмнө жилүүдэд өрхийн орлогын 54 орчим хувийг, цар тахлын үеэр өрхийн халамж, тэтгэмжийн орлого нэмэгдсэний нөлөөгөөр 48 орчим хувь болж буурч байв.


- Нийт өрхийн 41.7 хувийг 1,600 мянган төгрөгөөс бага орлоготой өрхүүд бүрдүүлж байгаа ба тэдгээрийн сарын дундаж орлого нэрлэсэн дүнгээр 1,049 мянган төгрөг байна.
- Харин нийт өрхийн 58.3 хувийг 1,600 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхүүд бүрдүүлж байгаа ба тэдний сарын дундаж орлого 3,189 мянган төгрөг буюу 1,600 мянгаас бага орлоготой өрхүүдийнхээс даруй 3 дахин өндөр байна.

- Орлогын өсөлт нийслэлд эрчимжиж байгаа бол хөдөө орон нутагт саарч, орлогын тэгш бус байдал нэмэгдэж байна.
- Мал аж ахуйгаас хараат, цалингаас хамааралгүй малчдын орлого тогтворгүй хэвээр байна.




ОХУ-ын Төв банк 2024 оны 7 дугаар сард сүүлийн долоон сарын хугацаанд 16 хувьд хадгалсан мөнгөний бодлогын хүүг, инфляцын өсөлтийг хянах зорилгоор 18 хувь болгож нэмэгдүүлэх шийдвэр гаргалаа.


БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ
(хувь)




ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ
(тэрбум ам.доллар)



ИНФЛЯЦ
(хувь)



ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) (нэгж)



- Дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар буурч, 4.0 хувийн өсөлттэй байлаа.
- ОХУ-ын цэргийн армийн зардлын өсөлтөөс шалтгаалсан төсвийн зардал тэлэлт, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой тэлэлттэй байсан эдийн засгийн өсөлт саарч, 2023 оны эхний улирлаас хойш доод үзүүлэлтэд хүрлээ.

- Экспорт 2024 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас 3.9 хувь, өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар тус тус өслөө.
- Экспортын өсөлтийг гэзрын тос, байгалийн хийн үнийн өсөлт голчлон дэмжсэн байна.
- Импорт 2024 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар буурсан байна.
- Импортын бууралтад рублийн ханш суларч, ложистикийн хүндрэл үүссэн нөхцөл байдал гол нөлөөлөл үзүүллээ.


- Инфляцын түвшин 2024 оны 7 дугаар сард өмнөх сараас 0.5 нэгж хувиар өсөж, 2023 оны 12 дугаар сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт 9.1 хувьд хүрлээ.
- Төв банк мөнгөний бодлогын хүүг инфляцын түвшин 2023 оны 12 дугаар сараас хойш аажмаар өсөж, зорилтот түвшин 4 хувиас давсан хэвээр байгаа тул 2 нэгж хувиар өсгөж, 18 хувь болгох шийдвэр гаргалаа.

- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2024 оны 7 дугаар сард 53.6 болж, өмнөх сарын үзүүлэлтээс 1.3 нэгжээр буурч, агшлаа.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2023 оны 4 дүгээр сараас хойш хамгийн бага буюу өмнөх оны мөн үеэс 3.8 нэгж хувиар буурч 1.9 хувийн тэлэлттэй байлаа.
- Аж үйлдвэрийн бодит өсөлтийн сааралтад үйлдвэрлэл, уул уурхайн салбарын үйлдвэрлэл огцом буурсан нь гол нөлөө үзүүлсэн байна.



2024 оны 7 дугаар сард аж үйлдвэрийн гарцын өсөлт саарсан ч жижиглэнгийн худалдааны өсөлтийн хурд нэмэгдэж, инфляц өмнөх сараас өслөө.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ
(хувь)




- 2024 оны 6 дугаар сард 8.6 хувь байсан экспортын өсөлт 2024 оны 7 дугаар сард 7.0 хувь болж саарав.
- Импорт 2024 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар өссөн байна.

АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ
(хувь)




- Аж үйлдвэрийн гарцын өсөлт 2024 оны 7 дугаар сард 5.1 хувь болж, өмнөх сараас 0.2 нэгж хувиар саарсан бол жижиглэн худалдааны өсөлт өмнөх сараас 0.7 нэгж хувиар өсөж, 2.7 хувьд хүрлээ.

ИНФЛЯЦ
(хувь)



- Хэрэглээний үнийн индексийн өсөлт 2024 оны 7 дугаар сард 0.5 хувь болж, өмнөх сараас 0.3 нэгж хувиар өслөө.
- Харин үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2024 оны 7 дугаар сард өмнөх сартай ижил - 0.8 хувьтай гарлаа.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)
(нэгж)



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2024 оны 7 дугаар сард 49.4 болж, 3 сар дараалан тэлэлтийг илтгэх босго утга 50-аас бага гарав.
- Харин аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас мөн өмнөх сараас буурсан ч босго утга 50-аас өндөр хэвээр байна.

Тус индекс нь богино хугацааны идэвхлэлийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ